



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/213

Арвайхээр

**Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл  
сунгах тухай**

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны 72 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Хархорин сумын хувийн хэвшлийн “Түмэн бялзуухай” цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай сунгасугай.

2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан “Түмэн бялзуухай” цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний бичилтийг хийж, олгох, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100473